



**МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 4990

Мандалговь

Г  
Дуудлага худалдаа зохион байгуулах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор батлагдсан 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу иргэн, аж ахуй нэгж байгууллагад худалдаа бүх төрлийн үйлчилгээ, амины орон сууцны зориулалтаар шинээр эзэмшүүлэх газрын дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга

Хөтлөгч: Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын төлбөр, үнэлгээ, татварын асуудал хариуцсан мэргэжилтэн

Тэмдэглэл хөтлөгч: Сайнцагаан сумын Газрын даамал

2. Газар эзэмших эрхийн дуудлага худалдаа явуулах ажлын журам, зааврыг баримтлан ил тод, нээлттэй явуулахыг ажлын хэсгийн дарга (Газрын удирдлагын хэлтсийн дарга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ



4822100031